

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬААТЫН ГАЗРЫН ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗРЫН  
ЗАХИРГААНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН ЦЭНДИЙН МӨНХТУЯАГИЙН  
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг.Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д                                                                                                                                     | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ                                                                                                           | Шалгуур үзүүлэлт                                                                                          | Гүйцэтгэлийн түвшин |                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |                           |                 |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------|---------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------|-----------------|
|                                                                                                                                         |                                                                                                                                            |                                                                                                           | Суурь түвшин        | Хүрэх түвшин                                                                                                                                                                  | Хүрсэн түвшин (биелэлт)                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           | Эхэлсэн, дууссан хугацаа  | Биелэлтийн хувь |
| 1                                                                                                                                       | 2                                                                                                                                          | 3                                                                                                         | 4                   | 5                                                                                                                                                                             | 6                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 | 7                         | 8               |
| Нэг. "Байгууллагын удирдлага, бүсийн газрын даргаас гаргасан шийдвэр, үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, тайлагнах" зорилтын хүрээнд |                                                                                                                                            |                                                                                                           |                     |                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   |                           |                 |
| 1.                                                                                                                                      | Арга хэмжээ №1.1.Бүсийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, Бүсийн газрын даргад хянуулан, Захиргаа, удирдлагын газарт хүргүүлэх. | -Нэгжийн даргад хянуулсан хугацаа,<br>-Захиргаа, удирдлагын газарт хүргүүлсэн албан бичгийн огноо, дугаар | 100%                | Бүсийн газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан, хянуулж Захиргаа, удирдлагын газарт тогтоосон хугацаанд хүргүүлэн, батлуулсан байна.                                     | Бүсийн газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулан, бүсийн газрын даргаар хянуулж 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр Захиргаа, удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Б.Очгэрэлд <a href="mailto:ochgerel.b@immigration.gov.mn">/ochgerel.b@immigration.gov.mn/</a> цахим хаягаар хүргүүлэн, 2024 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулсан.                     | 2023.12.11-<br>2024.06.05 | 100             |
| 2.                                                                                                                                      | Арга хэмжээ №1.2.Бүсийн газрын сар, улирлын тайлан, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнан ажиллах.                               | Сар, улирлын тайлангийн тоо, хүргүүлсэн албан бичгийн огноо, дугаар                                       | 100%                | Бүсийн газрын сар, улирлын болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийг хугацаанд нь Захиргаа, удирдлагын газрын ахлах мэргэжилтнүүдэд хүргүүлэн ажилласан байна. | Бүсийн газрын 1-6 дугаар сарын үйл ажиллагааны төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг сар бүрийн 01-ний өдөр Захиргаа, удирдлагын газрын ахлах мэргэжилтэн С.Мөнхтүвшинд цахимаар хүргүүлсэн. Бүсийн газрын 2024 оны 01 дүгээр улирлын ажлыг дүгнүүлсэн ба 2024 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайланг 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдөр хяналт шинжилгээ, үнэлгээ аудитын хэлтэст хүргүүлсэн. | 2023.12.11-<br>2024.06.05 | 100             |

| 1  | 2                                                                                                                                                                                                   | 3                                                                                                               | 4    | 5                                                                                    | 6                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   | 7                         | 8   |
|----|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------|------|--------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------|-----|
| 3. | Арга хэмжээ №1.3. Газрын дарга, албан хаагчидтай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний биелэлтийг дүгнэх ажлыг зохион байгуулан ажиллах.                                                        | -Гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулсан албан хаагчдын тоо,<br>-Дүгнэсэн дүнг хүргүүлсэн илтгэх хуудас, саналын тоо | 100% | Төлөвлөгөөний дагуу ажил, арга хэмжээ зохион байгуулсан байна.                       | Төрийн жинхэнэ 17 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг албан хэрэг хөтлөлтийн стандартад нийцүүлэн, бүсийн газрын даргаар батлуулсан.<br>Гүйцэтгэлийн төлөвлөгөө болон хөдөлмөрийн гэрээний биелэлтийг 1 дүгээр улирал болон хагас жилээр дүгнэх ажлыг зохион байгуулж, үнэлгээний жагсаалтыг илтгэх хуудсаар Үнэлгээний багт хүргүүлэн ажилласан.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                               | 2023.12.11-<br>2024.06.05 | 100 |
| 4. | Арга хэмжээ №1.4. Хөдөлмөрийн дотоод журам, байгууллагын даргын 2020 оны А/255, 2021 оны А/17 дугаар тушаалын хэрэгжилтийг тус тус ханган Бүсийн газарт ХАБЭА-г мөрдүүлэн, зааварчилга өгч ажиллах. | Ажил, арга хэмжээний тоо, зааварчилга авсан ажилтны тоо                                                         | 100% | Албан хаагчдад зааварчилга өгч, нэгээс доошгүй удаа сургалт зохион байгуулсан байна. | Бүсийн газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 16/04 дүгээр "Сургалт зохион байгуулах" удирдамжаар "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн тухай", "Хувь хүний эрх, үүрэг, хандлага, харилцаа" сэдвээр профессор, Монгол Улсын зөвлөх инженер П.Энхтайван 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдөр сургалт зохион байгууллаа.<br>Сургалтад бүсийн газрын 10 албан хаагч танхимаар хамрагдсан.<br>Бүсийн газар болон хилийн боомтод ажил үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдаа байгалийн давагдашгүй хүчин зүйл, гэнэтийн аюул ослоос урьдчилан сэргийлж аюулгүй ажиллагааны зааварчилга өгч, гарын үсгээр баталгаажуулан ажиллаж байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар анхан шатны зааварчилга 25, давтан зааварчилгыг давхардсан тоогоор 124 удаа 482 албан хаагчид тус тус өгсөн. | 2023.12.11-<br>2024.06.05 | 100 |

| 1                                                                                                                        | 2                                                                                                                        | 3                                                                                                 | 4    | 5                                                                                                                                                                                      | 6                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         | 7                     | 8   |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------|------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------|-----|
|                                                                                                                          |                                                                                                                          |                                                                                                   |      |                                                                                                                                                                                        | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны 07/00-00/001-01 дүгээр "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангаж ажиллах тухай" төрийн тусгайлсан чиг үүрэг хэрэгжүүлдэг албан хаагчдад зориулан гаргасан албан даалгаврын хэрэгжилтийг ханган 8 заалт бүхий төлөвлөгөө батлуулан, хэрэгжилтийг ханган аажиллаж байна.                                                                                                                                                 |                       |     |
| 5.                                                                                                                       | Арга хэмжээ №1.5. Албан хаагчдын цагийн бүртгэлийн тооцоо гаргах, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж ажиллах. | Албан хаагчийн тоо, үүрэг даалгаврын тоо, хэрэгжүүлсэн ажлын тухай хүргүүлсэн илтгэх хуудасны тоо | 100% | Цагийн бүртгэлийн тооцоог үнэн зөв гаргасан байна.                                                                                                                                     | Албан хаагчдын цагийн бүртгэлийн тооцоог 11 удаа гарган ажилласан.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        | 2023.12.11-2024.06.05 | 90  |
| Хоёр. "Байгууллагын даргын баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө, зорилтын хэрэгжилтийг тооцон тайлагнах" зорилтын хүрээнд |                                                                                                                          |                                                                                                   |      |                                                                                                                                                                                        |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                           |                       |     |
| 6.                                                                                                                       | Арга хэмжээ 2.1.Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах                      | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь                                                                   | 100% | Байгууллагын даргын баталсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулан, бүсийн газрын албан хаагчдад мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт зохион байгуулан, тайлагнан ажилласан байна. | Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор 2023 оны жилийн эцсийн ажлыг дүгнэж, үнэлэн 22 албан хаагчид 10,466,000 төгрөг, 2024 оны нэгдүгээр улирлын ажлыг дүгнэж, үнэлэн 20 албан хаагчид 11,506,500 төгрөгийн мөнгөн урамшуулал тушаалын төслийг боловсруулан, бүсийн газрын даргаар баталгаажуулсан. Төрийн үйлчилгээний 8 албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох тушаалын төслийг боловсруулан, хянуулж баталгаажуулсан. | 2023.12.11-2024.06.05 | 100 |
| 7.                                                                                                                       | Арга хэмжээ 2.2.Байгууллагын 2024 оны сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах                                        | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь                                                                   | 100% |                                                                                                                                                                                        | Байгууллагын даргын удирдамжаар зохион байгуулагдсан 4 удаагийн мэдээллийн цагийн сургалтад 62, бүсийн газрын даргын баталсан удирдамжаар зохион байгуулсан                                                                                                                                                                                                                                                                                                               | 2023.12.11-2024.06.05 | 90  |

| 1  | 2                                                                                                                      | 3                               | 4    | 5                                                                                                                        | 6                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              | 7                     | 8   |
|----|------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------|------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------|-----|
|    |                                                                                                                        |                                 |      |                                                                                                                          | <p>танхимын 8 удаагийн сургалтад 126, Төрийн албаны зөвлөлөөс Пүрэв гараг бүр зохион байгуулдаг вебинар 6 удаагийн сургалтад 51 албан хаагчийг тус тус хамруулсан.</p> <p>Байгууллагын даргын 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01-02/07 дугаар удирдамжаар "Хяналтын улсын байцаагчийг чадавхжуулах сургалт"-д 2 албан хаагч, 02 дугаар сарын 15-ны өдрийн 01-02/09 дүгээр удирдамжаар батлагдсан "Зөвлөгөө, мэдээлэл хариуцсан албан хаагчдыг дадлагажуулах сургалт"-д 3, байгууллагын даргын 2024 оны 01-02/25 дугаар "Шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх сургалт"-д 5 албан хаагчийг тус тус хамруулсан.</p>                                 |                       |     |
| 8. | <p>Арга хэмжээ 2.3.Албан хаагчдыг урт, богино хугацааны сургалт, цугларалтад хамруулах, мэдлэг чадварыг дээшлүүлэх</p> | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100% | <p>Байгууллагын даргын баталсан тушаалын дагуу албан хаагчид урт, богино, дунд хугацааны сургалтад хамрагдсан байна.</p> | <p>Удирдлагын академийн Төрийн албаны сургуулийн төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг чиглүүлэх сургалтад 2 албан хаагч, мэргэшүүлэх багц сургалтад 1 албан хаагч, байгууллагын даргын А/108 тушаалаар Хууль зүй дотоод хэргийн салбарын "Санхүүгийн нэгдсэн удирдлагын программ"-ын нэгдсэн цугларалтад 2, 2024 оны 01-02/19 дүгээр "Цугларалт зохион байгуулах тухай" удирдамжаар 2 албан хаагч 04 дүгээр сарын 24-25-ны өдрүүдэд хамрагдсан.</p> <p>Байгууллагын даргын 2024 оны А/162 дугаар тушаалаар 1 албан хаагч Бүгд Найрамдах Солонгос Улсын Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (КОЙКА)-аас Сөүл хотноо "Монгол Улсын Гадаадын</p> | 2023.12.11-2024.06.05 | 100 |

| 1   | 2                                                                                                                                      | 3                               | 4    | 5                                                                                          | 6                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  | 7                         | 8   |
|-----|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------|------|--------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------|-----|
|     |                                                                                                                                        |                                 |      |                                                                                            | иргэн, харьяатын газрын хүртээмжтэй үйлчилгээ, менежментийн чадавхийг бэхжүүлэх нь" сэдэвт сургалтад хамрагдсан.                                                                                                                                                                                                                                                                                   |                           |     |
| 9.  | Арга хэмжээ 2.4.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах           | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100% | Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, албан хаагчдад сургалт зохион байгуулж ажилласан байна. | Тус газарт шинээр томилогдсон 5, дэвшин томилогдсон 1 албан хаагчийн хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд мэдүүлүүлэн тус тус бүртгэсэн.<br>Төрийн хяналт, шалгалтын хуулийн дагуу батлагдсан төлөвлөгөөгөөр 6 удаагийн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт зохион байгуулсан 7 албан хаагчийн мэдэгдэл, тайлбарыг цахим системд хугацаанд нь бүртгэсэн. | 2023.12.11-<br>2024.06.05 | 100 |
| 10. | Арга хэмжээ 2.5.Жендерийн эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах            | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100% | Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, албан хаагчдад сургалт зохион байгуулж ажилласан байна. | Жендерийн эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор Дорнод аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан "Эрчүүдийн эрүүл мэнд" хөтөлбөрийн дагуу 2024 оны 03 дугаар сарын 18-ны өдөр бүсийн төвд үүрэг гүйцэтгэж байгаа 8 эрэгтэй албан хаагчид "Жендер ба эрчүүдийн эрүүл мэнд" сэдэвт сургалт зохион байгуулсан.                     | 2023.12.11-<br>2024.06.05 | 100 |
| 11. | Арга хэмжээ 2.6.Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр "Эцэг эхийн зөвлөл"-ийн үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | -    |                                                                                            | Бүсийн газрын 2 дугаар давхарт бага насны хүүхдээ хөхүүлэх, хүүхэд саатуулах зориулалт бүхий өрөө тохижуулсан.<br>Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр бүсийн газрын даргын 2023 оны А/21 дүгээр тушаалаар бүсийн газрын "Эцэг эхийн зөвлөлийг байгуулсан.                                                                                                                                          | 2023.12.11-<br>2024.06.05 | 90  |

| 1                                                                                                                                                      | 2                                                                                                        | 3                                      | 4    | 5                                                                                          | 6                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                      | 7                         | 8   |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------|------|--------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------|-----|
|                                                                                                                                                        |                                                                                                          |                                        |      |                                                                                            | Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газраас 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулсан "Эмэгтэйчүүдийн сэтгэл зүй, хүүхдийн хөгжил, хамгаалал" сэдэвт уулзалтад тус газрын 3 албан хаагчийг оролцуулсан.                                                                                                                                                                                                                                           |                           |     |
| 12.                                                                                                                                                    | Арга хэмжээ 2.7. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх      | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь        | 100% | Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, албан хаагчдад сургалт зохион байгуулж ажилласан байна. | Байгууллагын даргын баталсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 2023 оны төлөвлөгөө"-ний жилийн эцсийн, 2024 оны эхний хагас жилийн биелэлтийг гарган 2023 оны 12 дугаар сарын 25, 2024 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Захиргаа, удирдлагын газарт тус тус хүргүүлсэн.<br>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд нийт албан хаагчдад цахимаар 2 удаагийн зөвлөмж өгч, Захиргаа, удирдлагын газрын даргаас ирүүлсэн 01 дүгээр үүрэг, чиглэлийг танилцуулж, гарын үсгээр баталгаажуулсан. | 2023.12.11-<br>2024.06.05 | 100 |
| Гурав. "Хүний нөөцийн талаарх судалгаа гаргах, хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлэх, сургалт, цугларалт зохион байгуулах" зорилтын хүрээнд |                                                                                                          |                                        |      |                                                                                            |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                        |                           |     |
| 13.                                                                                                                                                    | Арга хэмжээ №3.1. Хүний нөөцийн системийн программд албан хаагчдын мэдээллийг тухай бүр шинэчлэн оруулах | -Албан хаагчийн тоо                    | 100% | Программын хөгжүүлэлтийг ханган ажилласан байна.                                           | Байгууллагын даргын 2024 оны А/158 дугаар "Гадаадын иргэн, харьяатын газрын хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн батлах тухай" тушаалын дагуу бүсийн газрын 27 албан хаагчийн мэдээллийг шинэчлэн оруулсан.                                                                                                                                                                                                                                    | 2023.12.11-<br>2024.06.05 | 100 |
| 14.                                                                                                                                                    | Арга хэмжээ №3.2. Хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжид шаардлагатай захиалгат судалгааг гарган         | -Хүргүүлсэн судалгааны тоо, судалгаанд | 100% | Шаардлагатай судалгааг үнэн зөв, бодитой боловсруулж,                                      | Захиргаа, удирдлагын газарт албан хаагчдаас 5 удаа судалгаа авч хүргүүлсэн.                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                            | 2023.12.11-<br>2024.06.05 | 100 |

| 1                                                                                                                                                        | 2                                                                                                                                                                                    | 3                                                                                      | 4    | 5                                                                                                                                                          | 6                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     | 7                     | 8   |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------|------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------|-----|
